



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/11

Жаргалтхаан сум

**Дэмжлэгийн баг шинэчлэн
байгуулах тухай**

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын 3.2.1.3 дахь заалт, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын А/292, А/155, А/425 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийг тэгш хамран сургах, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, адил тэгш, чанартай боловсрол олгох ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах зорилгоор сургууль дээрх "Дэмжлэгийн баг"- ийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Багийн ахлагч: Д.Бямбадорж – Сургалтын менежер

Гишүүд: О.Түвшинбаяр – Нийгмийн ажилтан

С.Мэндээ – Бага ангийн багш


Г.Уранзаяа – Бага ангийн багш

Ж.Хүрэлцэцэг – Бага ангийн багш

2. Холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжилтийн тайлан мэдээг улирал бүр тайлагнан ажиллахыг багийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Дэмжлэгийн баг байгуулах тухай" захирлын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/4 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



С.ОЮУНЦЭЦЭГ

D/Tushaal-2026
232601021